



**БУЛГАН АЙМГИЙН САЙХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 28

Их хүрэмт

Г

Г


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах хөтөлбөр батлах тухай

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар сарын 25 ны өдрийн 183-р тогтоол, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24-р зүйл, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.13-ийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах сумын дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх тайланг хагас бүтэн жилээр тэргүүлэгчдэд тайлагнаж, үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24-р зүйлийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга /Н.Мэнд-Амар/, хөдөлмөр-хэвлэл мэдээллийн ажилтан/ Б.Цэрэннадмид/ нарт даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Даваа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  А.БАДАМСҮРЭН

